



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 07

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйл, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам"-ын 2.1, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрхангай сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 17'750'000 /арван долоон сая долоон зуун тавин мянга/ төгрөгний анхны өртөгтэй, 9'508'926 /есөн сая таван зуун найман мянга есөн зуун хорин зургаа/ төгрөгний үлдэгдэл өртөгтэй, 39-39 ДУА улсын дугаартай, УАЗ-31512-2 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Автомашиныг худалдах үнийн доод хязгаарыг 2'000'000 /хоёр сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

3. Худалдсан тээврийн хэрэгслийг хөрөнгийн бүртгэлээс хасахыг Дэлгэрхангай сумын ЗДТГ-ын дарга /Н.Дашцэрэн/ -д даалгасугай.

ДАРГА



С.БУДЖАВ

100000548